



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.12.16 № А-1/973
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Р.СЭДДОРЖ ТАНАА

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу Эрдэнэсийн сангийн 2025 оны төсвийн гүйцэтгэл, 2026 оны төсвийн төслийн танилцуулга, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж байна.

Эрдэнэсийн сангийн 2025 оны үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайлан, 2026 оны үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт //... хуудас.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525032659

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО,
ГҮЙЛГЭЭ САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү тайланг боловсруулахдаа Эрдэнэсийн сангийн тухай хууль, Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсөв”, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам, Дурсгалын зоос үйлдвэрлүүлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах журам, Үнэт металлын үйл ажиллагааны журам, Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэр, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг үндэслэв.

Хоёр. Эрдэнэсийн сангийн төсвийн гүйцэтгэл

Монголбанкны Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар 2025 оны төсвийн гүйцэтгэл, 2026 оны төсвийн төслийн тайланг хэлэлцэв.

2025 онд Эрдэнэсийн сангаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Чингис хаан алтадсан хүрэл барималыг Чингис хаан үндэсний музейн 9 давхарт дэглэн, барималын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.
2. Чингис хаан барималын нээлтийн үйл ажиллагаанд зориулан баримал бүтсэн тухай каталогийг хэвлүүлэв.
3. Монгол Улсад төгрөг үүсэж бэхэжсэний 100 жилийн ойг тохиолдуулан Мөнгөн тэмдэгтийн үзмэрийн танхимын дэргэд жижиг танхимыг нээсэн.
4. Шинжлэх Ухааны Академийн Хэл, зохиолын хүрээлэнтэй хамтран “Төгрөг 100” судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн.
5. 2025 оны Түүх, Соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын нэгдсэн тооллогод Эрдэнэсийн сангийн сан хөмрөгт байгаа эд зүйлсийн бүртгэлийн тулган баталгаажуулан хамрагдав.

“Эрдэнэсийн сангийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт Улсын Их Хурал нь Эрдэнэсийн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2025 оны төсөв” батлагдсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Эрдэнэсийн сангийн 2025 оны төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Бүлэг	Хэмжих нэгж	2025 төсөв	Гүйцэтгэл
1. Үндсэн сангийн орлого				
1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл түүний засвар сэргээн засварлах, байгалийн төрц алт худалдан авах, архелог, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая.төгрөг	2,000.0	100.0
2	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж	ширхэг	гүйцэтгэлээр	162

3	1945 оны зоосон мөнгө	ширхэг	2,000	2,000
4	Монголбанкны “Хүндэт банкир” жижиг тэмдэг, хайрцаг	ширхэг	3	3
2. Гүйлгээ сангийн орлого:				
1	2025 онд үйлдвэрлэсэн дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр	5,701
3. Гүйлгээ сангийн зарлага:				
Дурсгалын зоос, алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгө:		ширхэг	24,500	3,772
1	1.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,300	3,588
	1.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200	184
4. Бусад				
1	Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажил	сая.төгрөг	200.0	46.8

I. Эрдэнэсийн сангийн 2025 оны үндсэн сангийн орлогын гүйцэтгэл

1.1 2025 онд Монголбанк 2,0 тэрбум төгрөгөөр Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төрц худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологийн олдворын сэргээн засварлах ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг хийхээр төсөвлөснөөс гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 5 иргэнээс эд зүйлс худалдах тухай хүсэлт ирснээс “Жанрайсаг бурхан”-г 100 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулан, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, эд зүйлийг хүлээн авч Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэв. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Эрдэнэсийн сангийн 2025 оны төсвийн гүйцэтгэл

№	Эд зүйлсийн нэр	Үнийн дүн /сая төгрөг/	Тайлбар
1	Жанрайсаг бурхан	100.0	Иргэн Д.Энхмаатай “Худалдах, худалдан авах” 0525/327 дугаар гэрээ байгуулан эд зүйлийг худалдан авсан.
Нийт дүн		100.0	

1.2 2025 онд үйлдвэрлэгдсэн Монголбанкны дурсгалын зоосны дээж болон франчайз зоосыг гүйцэтгэлээр орлогод авахаар төлөвлөсөн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 162 ширхэг дурсгалын зоосны дээжийг хүлээн авч, Үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэв. /Хүснэгт 3/

Хүснэгт 3. Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж

№	Зоосны сэдэв	Металл	Жин /грамм/	Худалдаанд гарсан он	Тоо /ширхэг/
Монголбанкны санаачилгаар:					
1	"Чингис хаан" 1 кг /алтан/	Алт	1,000	2024	5
2	"Нэг төгрөг" /мөнгөн/	Мөнгө	31.1	2025	5
3	"Нэг төгрөг" /алтан/	Алт	31.1	2025	5
4	"100 Төгрөг" ялтсан дэвсгэрт	Алт	3.0	2025	5
5	Морь жил /Монгол/	Мөнгө	31.1	2026	5

Байгууллагын хүсэлтээр:					
1	"Занабазар 390"	Мөнгө	62.2	2025	5
2	"Голомт банк 30 жил" /1унц/	Мөнгө	31.1	2025	5
3	"Голомт банк 30 жил" ялтсан дэвсгэрт	Алт	1.0	2025	5
4	"Нисэх хүчин 100 жил"	Мөнгө	31.1	2025	5
5	"Автотээвэр 100 жил"	Мөнгө /алтадсан/	31.1	2025	5
Франчайз зоос					
1	Цагаан хэрэм /3 унц/	Мөнгө	93.3	2025	5
2	Луу жил /алт/	Алт	0.5	2024	5
3	Луу жил /мөнгөн/	Мөнгө	31.1	2024	5
4	Луу /мөнгөн тэсрэлт /	Мөнгө	500.0	2024	1
5	Луу жил /алтадсан/	Мөнгө	31.1	2024	5
6	Фаберже өндөг /Imperial Coronation Egg/	Мөнгө	62.2	2024	2
7	Монгол шонхор /5 унц/	Мөнгө	155.5	2023	2
8	Ирвэс /3 унц/	Мөнгө	93.3	2024	2
9	Ирвэс /1 унц/	Мөнгө	31.1	2024	5
10	Ирвэс /алтан 1/10 унц/	Алт	3.1	2024	1
11	Манзушир Мандал /мөнгөн/	Мөнгө	93.3	2024	5
12	Манзушир Мандал /өнгөт/	Мөнгө	93.3	2024	2
13	Манзушир Мандал /алтадсан/	Мөнгө	93.3	2024	5
14	Баавгай /Woodland Spirits/	Мөнгө	31.1	2024	5
15	Ирвэс /зэс/	Зэс	50.0	2024	5
16	Ирвэс /2 унц/	Мөнгө	62.2	2024	2
17	Могой жил /ялтсан дэвсгэрт/	Мөнгө	5.0	2025	5
18	Могой жил /алтан/	Алт	0.5	2025	5
19	Могой жил /мөнгөн/	Мөнгө	31.1	2025	5
20	Үлэг гүрвэл Aves /мөнгөн/	Мөнгө	31.1	2024	5
21	Үлэг гүрвэл Aves /алтан/	Алт	0.5	2024	5
22	Могой жил /алтадсан/	Мөнгө	31.1	2025	5
23	Таж Махал	Мөнгө	62.2	2025	5
24	Тиффани Арт-Вашингтон	Мөнгө	93.3	2025	5
25	Нью-Йорк /3 унц/	Мөнгө	93.3	2025	5
26	Бизон /1 унц/	Алт	31.1	2025	5
27	Маттерхорн	Мөнгө	31.1	2025	5
Нийт дүн					162

1.3– 1.4 Эрдэнэсийн сангийн Үндсэн санд 1945 оны зоосон мөнгөн тэмдэгт 2,000 ширхэг, Монголбанкны “Хүндэт банкир” том, жижиг тэмдэг, хайрцаг нийт 3 ширхгийг орлогоор бүртгэн авсан.

II. Эрдэнэсийн сангийн 2025 оны гүйлгээ сангийн орлого, зарлагын гүйцэтгэл.

1. Орлого

1.1 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монголбанкны санаачилгаар болон франчайзаар үйлдвэрлэсэн дурсгалын зоос, үрлэн мөнгө, гулдмай 5,701 ширхгийг Эрдэнэсийн сангийн гүйлгээ санд орлогоор бүртгэн авсан.

2. Зарлага

2.1 Дурсгалын зоосны 2025 оны үйл ажиллагаа:

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дах заалтад “Үнэт болон бусад металлаар хийсэн дурсгалын зоос гаргах” гэж заасны дагуу 2025 онд Монголбанк 4 төрлийн дурсгалын зоос, байгууллагын захиалгаар 5 төрлийн дурсгалын зоос үйлдвэрлүүлсэн байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Монголбанк, байгууллагын хүсэлт санаачлагаар үйлдвэрлүүлсэн дурсгалын зоос.

№	Дурсгалын зоосны нэр	Тайлбар
1.	“Нэг төгрөг” /алтан/	Орчин цагийн “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан “Нэг төгрөг” дурсгалын зоосыг 1 унцын хэмжээтэйгээр алт, мөнгөн төрлөөр.
2.	“Нэг төгрөг” /мөнгөн/	
3.	“100 Төгрөг”	Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан “100 Төгрөг” алтан ялтсан дэвсгэртэйг 3 граммын хэмжээтэйгээр.
4.	“Морь жил”	2020 оноос эхлэн гаргасан 12 жилийн цуврал дурсгалын зоосны үргэлжлэл “Морь жил” дурсгалын зоосыг.
5.	“Голомт банк 30 жил” /мөнгөн зоос/	Голомт банкны 30 жилийн ойг тохиолдуулан 1 унцын мөнгөн зоос, алтан ялтсан 1 граммын дэвсгэртэйг хэмжээтэйгээр.
6.	“Голомт банк 30 жил” /алтан ялтас/	
7.	“Нисэх хүчин 100 жил”	Иргэний нисэхийн ерөнхий газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан “Нисэх хүчин 100 жил” 1 унцын дурсгалын зоос.
8.	“Автотээвэр 100 жил”	Монгол Улсын Зам, тээврийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Автотээвэр 100 жил” 1 унцын алтадсан мөнгөн дурсгалын зоосыг үйлдвэрлүүлсэн.
9.	“Занабазар 390 жил”	Анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойг тохиолдуулан “Занабазар 390” 2 унцын дурсгалын мөнгөн зоос.

- “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсөв”-т гүйлгээ сангаас 24,500 ширхэг дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар төсөвлөсөн байна.

Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас иргэд, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан үнээр худалдаалдаг бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оны эхнээс нийт 1,938.83 сая төгрөгийн өртөг бүхий 3,656 ширхэг дурсгалын зоос, 4,260.46 сая төгрөгийн өртөг бүхий 905 ширхэг алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг нийт 11,927.30 сая төгрөгөөр худалдсан байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгөний зарлага. /2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар/

Он	Дурсгалын зоос		Алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө		Нийт өртөг /сая төг/
	тоо ш	өртөг /сая төг/	тоо /ш	өртөг /сая. төг/	
2018	360	31.33	-	-	31.33
2019	569	76.92	-	-	76.92
2020	606	114.74	190	438.93	553.67
2021	4,531	875.77	807	5,356.65	6,232.42
2022	2,973	566.79	234	795.05	1,361.85
2023	5,889	940.98	855	2317.64	3,258.92

2024	4,419	879.21	1,422	3,769.09	4,648.30
2025.11.30	3,656	1,938.83	905	4,260.46	6,199.29

2.1.2 Энэ оны төсөвт зочин төлөөлөгчийн зардлаар бэлэг дурсгалд 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар тусгагдсанаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр 192 ширхэг дурсгалын зоос зарцуулсан байна.

Франчайз зоос борлуулсны шимтгэл /роялти төлбөр/:

Монголбанк, Койн Инвест Траст компанитай 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Зоос үйлдвэрлэх ерөнхий гэрээ”-ний дагуу Койн Инвест Траст компани нь дурсгалын зоосны борлуулалтын шимтгэлийг улирал бүр Монголбанкны дансанд шилжүүлсэн бөгөөд 2025 оны III улирлын байдлаар нийт 12,439 ширхэг дурсгалын зоос борлуулж 80.3 сая төгрөгийн борлуулалтын шимтгэл төлсөн байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6. Дурсгалын франчайз зоос борлуулсны шимтгэлийн орлого 2025 оны III улирлын байдлаар, Монголбанкны дансанд орсон өдрийн валютын ханшаар тооцсон.

№	Улирал	Худалдан борлуулсан зоосны тоо ширхэг	Борлуулалтын шимтгэлийн төлбөр	
			Евро	Төгрөг
1	I	2'165	7,776.00	28,201,063.68
2	II	6'662	8,756.70	31,757,748.76
3	III	3'612	5,617.30	20,372,149.56
Нийт		12'439	22'150.00	80,330,962.00

III. Бусад зардалын гүйцэтгэл

3.1 Үзэсгэлэн зохион байгуулах зардал.

Чингис хаан барималын үзэсгэлэнгийн нээлт болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажлын зардалд 2025 онд нийт 200 сая төгрөгийг төсөвлөснөөс 46.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. /Хүснэгт 7/

Хүснэгт 7. Бусад зардалаар гарсан ажлын гүйцэтгэл

№	Хийгдсэн ажил	Үнийн дүн /сая төгрөг/	Гэрээний дугаар, Тайлбар
1	Чингис хаан барималын баримтат нэвтрүүлгийн зардал.	15.0	0523/244 Чингис Хаан Музейтэй байгуулсан гэрээний дагуу шилжүүлсэн төлбөр.
2	Чингис хаан каталогийн эх бэлтгэл, зураг авалт, орчуулга, хэвлэлийн зардал.	31.8	0525/93 тоот Хэвлэлийн гэрээ 0524/494 тоот Гэрэл зураг авалтын гэрээ 0525/94 тоот Эх бэлтгэлийн гэрээ 0525/92 тоот Орчуулагийн ажлын гэрээ
Нийт дүн		46.8	

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ГҮЙЛГЭЭ САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2026 оны төсвийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар тогтоолын төслийн танилцуулгыг боловсруулан танилцуулж байна.

Эрдэнэсийн сангийн 2026 оны төсвийн төслийг Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д “Эрдэнэсийн сан нь эрдэнэс худалдан авахад санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлтэй байна.” гэж заасны хүрээнд Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцсэн.

Нэг. Үндсэн сангийн орлого.

2026 онд Монголбанкнаас Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн сан хөмрөгийг дараах байдлаар нэмэгдүүлж, үндсэн санд орлогоор бүртгэхээр төлөвлөлөө.

- 1.1 Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн төрц алт худалдан авах, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад 2.0 тэрбум төгрөг зарцуулах.
- 1.2 Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээжийг орлогоор бүртгэх.

Хоёр. Гүйлгээ сангийн орлого.

- 2.1 2026 онд үйлдвэрлэгдэх дурсгалын зоос болон бусад эд зүйлийг орлогоор бүртгэнэ.

Гурав. Гүйлгээ сангийн зарлага.

- 3.1 Гүйлгээ сангаас 24,500 ширхэг дурсгалын зоос болон гулдмай, үрлэн мөнгө зарлагадахаар тусгаснаас худалдах зориулалтаар 24,300 ширхгийг, зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг мөнгө, зэс дурсгалын зоос зарцуулахаар төлөвлөв.

Дээрх гүйлгээ сангаас зарлагадахаар төсөвлөсөн дурсгалын зоос болон гулдмай, үрлэн мөнгөнд 2026 онд Монголбанк шинээр цутгуулах зоосны төрөл нэмж тооцогдоогүй.

**Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого,
гүйлгээ сангийн орлого, зарлагын 2026 оны төсөв**

Хүснэгт 1. Эрдэнэсийн сангийн 2026 оны төсвийн төсөл, хураангуй.

1.Үндсэн сангийн орлого:		Хэмжих нэгж	2025 Батлагдсан	2026 Төсөв
1.	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн төрц алт худалдан авах, , түүх, архелогийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая төгрөг	2,000.0	2,000.0
2.	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж.	ширхэг	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр
2.Гүйлгээ сангийн орлого:				
1	2026 онд үйлдвэрлүүлэх дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр
3.Гүйлгээ сангийн зарлага:				
	Дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө.			
1	2.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,300	24,300
	2.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200	200
4. Бусад:				
1	Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажил	сая.төгрөг	200.0	-

2026 оны дурсгалын зоосны үйл ажиллагаа:

2026 онд тохиох тэмдэглэлт ой, онцгой чухал үйл явдлын товчоог Хүснэгт 2-д харуулав.

Хүснэгт 2: Тэмдэглэлт ойн товчоо.

2026 онд тохиох тэмдэглэлт ойн сэдэв:		
Он, цаг хугацаа		Тайлбар
Хонь жил		Монголбанкны санаачилгаар гаргаж байгаа цуврал зоос 2027 онд тохиох “Хонь жил”
Тахилгат уул		Монгол Улсын Тахилгат Уулс сэдвээр шинэ цуврал эхлүүлэх.
Бух		Монголын Банкны Холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу дурсгалын зоос гаргахаар ажиллаж байна.
Хүний эрхийн байгууллага		2026 онд Монгол Улсад Хүний эрхийн байгууллага үүсэж хөгжсөний түүхэн 25 жилийн ой
Олон улсын дипломат харилцаа		Дипломат харилцаа тогтоосны ойн хүрээнд
1206	820 жилийн ой	Их Монгол Улс байгуулагдсаны 820 жилийн ой
1727	299 жилийн ой	Амарбаясгалант хийдийн 299 жилийн ой
1921	105 жилийн ой	Ардын хувьсгалын 105 жилийн ой
Бусад		2026 онд тохиох бусад тэмдэглэлт ой, онцгой чухал үйл явдлын сэдвээр хийлгэх.

Монголбанкны Эрдэнэсийн сангаас 2026 онд дараах сэдвээр дурсгалын зоос үйлдвэрлүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. “Хонь жил” дурсгалын зоос:

Монголбанкны санаачилгаар 2020 онд 12 жилийн цуврал дурсгалын зоосыг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2020 онд “Хулгана жил”, 2021 онд “Үхэр жил”, 2022 онд “Бар жил”, 2023 онд “Туулай жил”, 2024 онд “Луу жил”, 2025 онд “Могой жил”, “Морь жил”-ийн дурсгалын мөнгөн зоосыг Койн инвест Траст компанид үйлдвэрлүүлж хүлээн авч, худалдаалж байна. Уг цувралын үргэлжлэлээр 2027 онд тохиох “Хонь жил” дурсгалын зоосыг 2026 онд захиалан үйлдвэрлүүлнэ.

2. “Монгол Улсын Тахилгат Уулс” дурсгалын зоос

Монгол Улсын Тахилгат Уулс сэдвээр шинэ цуврал эхлүүлэн дурсгалын зоос гаргахаар ажиллаж байна.

3. “Бух” дурсгалын зоос

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн салбарын байгууллагууд хамтран 2024 онд хөрөнгийн зах зээлийн өсөлт, хүч чадлыг бэлгэдэн бүтээлгэсэн “Бух” хөшөөний загвараар Монголын Банкны Холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу дурсгалын зоос гаргахаар ажиллаж байна.

4. “Монгол Улсын Хүний эрхийн байгууллага 25 жил” дурсгалын зоос

2026 онд Монгол Улсад Хүний эрхийн байгууллага үүсэж хөгжсөний түүхэн 25 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоосоос ирүүлсэн хүсэлтийн дагуу дурсгалын зоос үйлдвэрлүүлэн гаргахаар хамтран ажиллаж байна.

5. “Амарбаясгалант хийд 300 жил” дурсгалын зоос

Амарбаясгалант хийдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2027 онд тохиох Амарбаясгалант хийдийн 300 жилийн ойг тохиолдуулан “Амарбаясгалант хийд 300” дурсгалын зоосыг 2026 онд захиалан үйлдвэрлүүлэхээр ажиллаж байна.

6. Бусад

2026 онд тохиох тэмдэглэлт ой, онцгой чухал үйл явдлын хүрээнд Мандалын Бат-Очир сан, Ү. Ядамсүрэн сан болон Монгол Шуудан компаны маркын газартай хамтран ажиллах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ... сарын өдөр

Дугаар

Төрийн ордон. Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН
ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ГҮЙЛГЭЭ САНГИЙН ОРЛОГО,
ЗАРЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ,
2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэлийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2026 оны төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН
ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ГҮЙЛГЭЭ САНГИЙН ОРЛОГО,
ЗАРЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

№	Бүлэг	Хэмжих нэгж	2025 төсөв	Гүйцэтгэл
1. Үндсэн сангийн орлого				
1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл түүний засвар, сэргээн засварлалт, байгалийн төрц алт худалдан авах, архелог, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая.төгрөг	2,000.0	100.0
2	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж	ширхэг	гүйцэтгэлээр	162
3	1945 оны зоосон мөнгө	ширхэг	2,000	2,000
4	Монголбанкны “Хүндэт банкир” жижиг тэмдэг, хайрцаг	ширхэг	3	3
2. Гүйлгээ сангийн орлого:				
1	2025 онд үйлдвэрлэсэн дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр	5,701
3. Гүйлгээ сангийн зарлага:				
Дурсгалын зоос, алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгө:		ширхэг	24,500	3,772
1	1.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,300	3,588
	1.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200	184
4. Бусад				
1	Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажил	сая.төгрөг	200.0	46.8

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН
ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ГҮЙЛГЭЭ
САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2026 ОНЫ ТӨСӨВ

Бүлэг		Хэмжих нэгж	2026 Төсөв
1. Үндсэн сангийн орлого:			
1.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн төрц алт худалдан авах, түүх, археологийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах.	сая төгрөг	2,000.0
1.2	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж.	ширхэг	гүйцэтгэлээр
2. Гүйлгээ сангийн орлого:			
2.1	2026 онд үйлдвэрлүүлэх дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр
3. Гүйлгээ сангийн зарлага:			
3.1	Дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө.		
	2.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,300
	2.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200
4. Бусад:			